



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар

A/244

Улаанбаатар хот

Газрын зөрчил арилгах талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5, 57 дугаар зүйлийн 57.4, 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.5, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/211 дүгээр захирамж, А/234 дугаар захирамж, А/237 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг хааж зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр барьсан өргөтгөл болон байрлуулсан зөөврийн байгууламж, стандарт бус тохижилт, хашаа, хайс, хаалт, автомашины гараашийг албадан буулгах, орц, гарц гаргах, үерийн далан суваг, гуу жалгыг зохих зөвшөөрөлгүй хаасан, суурьшсан талбай, мухар гудамжийг чөлөөлөх ажлыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ж.Тамир)-д үүрэг болгосугай.

2.Газрын зөрчил арилгах, газар чөлөөлөх, тохижилт хийх талаар арга хэмжээ авч ажиллахад төрийн байгууллагын үйл ажиллагааг саадгүй явуулах, нийтийн эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, зохих арга хэмжээ авч хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн нэгдүгээр хэлтэс (Ц.Түвшинжаргал), Цагдаагийн хоёрдугаар хэлтэс (Ү.Анхбаяр), Замын цагдаагийн хэлтэс (Г.Золжаргал)-т тус тус даалгасугай.

3.Чөлөөлөгдсөн нийтийн эдэлбэрийн газрын хамгаалалт, арчилгааг хариуцах, тухайн байршилд тохижилтын ажил хийж гүйцэтгүүлэхийг Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Ц.Батжанцан)-т даалгасугай.

4.Дээрх газар албадан чөлөөлөх, тохижуулах ажлыг зохион байгуулахад шаардагдах төсвийг холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т зөвшөөрсүгэй.

5.Холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Хурцбаяр)-т даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010735